



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**ГАЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАВААГИЙН
БЯМБАЖАВ ТАНАА**

2020.09.03 № 007-2020/06-НД-52
танай _____ -ны № _____ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Даваагийн Бямбажавын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Д.Бямбажав нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Д.Бямбажавын Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Д.Бямбажавын мөрийн хөтөлбөр /...../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАВААГИЙН БЯМБАЖАВЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

4317143998
МЮА0065 9055436

Уриа: ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ, ОЛОЛТЫГ АХИУЛЬЯА.

НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ-ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 1.1. Орон нутгийн хөгжлийн бодлогыг иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны зарчмаар тодорхойлж, иргэдийн ажиллаж амьдрах, эрүүг тохилог, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “Орон нутгийн хөгжлийн сан”-г журмын дагуу сумын хэтийн хөгжлийн төлөвлөлтөд чиглүүлэн хэрэгжүүлэхийн төлөө холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.2. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эмийн бус үйлчилгээг өргөжүүлэх, эрүүл зан үйлийг бий болгох сургалт сурталчилгааны ажлын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжсэн орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллана.
- 1.3. Иргэдэд газар өмчлүүлэх ажлыг нээлттэй, ил тод болгож, газрын төлөвлөгөөг орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар ил мэдээлдэг болгоход анхаарч ажиллана.

ДЭД БҮТЭЦ- ХӨГЖЛИЙН ҮҮД:

- 2.1. Сум доторх төв зам дагуу болон хорооллын дундах замын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.2. Цэвэр усны хүртээмжийг сайжруулахын тулд гүний худгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр санал, санаачилга гаргаж, шийдвэрлүүлнэ.
- 2.3. Суманд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах замаар тохижилт үйлчилгээ, хогны асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

ЭДИЙН ЗАСГИЙН ТААТАЙ ОРЧИН- АМЬДРАЛЫН БАТАЛГАА:

- 3.1. Сумын ард иргэдийн санал санаачилгад тулгуурлан тохижилтын аян, иргэдийн оролцоотой бусад үйл ажиллагаа, тэмцээн уралдааныг дэмжин ажиллана.
- 3.2. Амьжирагааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой ядуу, нэн ядуу айл өрхийг малжуулах, зөгий, гахай, тахиа үржүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, төсөл хөтөлбөрт хамрагдах боломж, нөхцөлийг судалж, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.3. Хүүхдийн өвчлөлийг бууруулах, иргэдийг эрүүлжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд орон нутагт хувийн шүдний эмнэлэг байгуулах боломж, нөхцөлийг судалж, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.

Бие даан нэр дэвшигч

Д.Бямбажав

2020 оны 07-р сарын 24